# 8-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН
# АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ
# “А” ХУВИЛБАРЫН ТҮЛХҮҮР

| Д\Д | ЗӨВ ХАРИУЛТ | ОНОО |
|---|---|---|
| **1** | D | 2 |
| **2** | B | 2 |
| **3** | B | 2 |
| **4** | B | 2 |
| **5** | B | 2 |
| **6** | A | 2 |
| **7** | A | 2 |
| **8** | D | 2 |
| **9** | B | 2 |
| **10** | C | 2 |
| **11** | C | 2 |
| **12** | B | 2 |
| **13** | A | 2 |
| **14** | C | 2 |
| **15** | C | 2 |
| **16** | A | 2 |
| **17** | B | 2 |
| **18** | A | 2 |
| **19** | D | 2 |
| **20** | D | 2 |
| **21** | B | 2 |
| **22** | C | 2 |
| **23** | A | 2 |
| **24** | D | 2 |
| **25** | C | 2 |
| **26** | A | 2 |
| **27** | D | 2 |
| **28** | A | 2 |
| **29** | C | 2 |
| **30** | B | 2 |
| **31** | D | 2 |
| **32** | **B**] | 2 |
| **33** | A | 2 |
| **34** | B | 2 |
| **35** | C | 2 |
| **1-Р ХЭСЭГ** | | 70 |
| **36** | Эрх зүйн зарим чадвар | 6 |
| **37** | 1. Газар 2. Хөдөлмөр | 6 |
| **38** | Иргэдийн нийгтийн хурал | 6 |
| **39** | Байгууллага | 6 |
| **40** | Ёс зүйн дүрэм | 6 |
| **2-Р ХЭСЭГ** | | 30 |
| **НИЙТ** | | 100 |

БАТЛАВ:

ЗАХИРАЛ Б.БАТСҮХ

2024.06.03.

ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 8-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛЭЭР АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

**ХУВИЛБАР "А"**

Хугацаа: 60 минут Сурагчийн нэр:

Нийт оноо: 100 Нэгдүгээр хэсэг 35 даалгавар 70 оноо

Хоёрдугаар хэсэг 5 даалгавар 30 оноо

**САНАМЖ**

- Даалгаврыг 60 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

**1.** Хүндлэл хүлээх хэрэгцээнээс аль нь илүүц вэ? \2 оноо \

A. Амжилт B. Байр суурь C. Хариуцлага D. Ажил

**2.** Хүний хэрэгцээний шатлалыг хэн боловсруулсан бэ? \2 оноо \

A. О. Конт B. А. Маслоу C. Э. Дюркгейм D. Томас-Киллман

**3.** Хүмүүс өөртөө байхгүй зүйлийг бусдаас авах, солилцоо хийх замаар бусадтай харилцдаг гэж үзсэн. Үүнийг ямар нэр томьёогоор тайлбарласан бэ? \2 оноо \

A. Механик эв нэгдэл C. Хэрэгцээний онол

B. Органик нэгдэл D. Томас-Киллманы загвар

4. Монгол улсын харьяат ................. насны бүх хүн иргэний үнэмлэхтэй байна. \2 оноо \

A. 18-аас дээш B. 16-аас дээш C. 18-аас доош

5. Иргэний үнэмлэхийг 25 нас, ...... насанд тус бүрд шинэчлэн солих журамтай. \2 оноо \

A. 35 B.45 C.55 нас

6. Монгол улсын иргэн оршин суугаа сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэний үнэмлэх авах тухай ....................... гаргана. \2 оноо \

A. Өргөдөл B. Хүсэлт C. Гомдол

7. Зөрчилдөөний ангиллуудын өгөгдлүүдийг дараах хүснэгтэд зөв байршуулсныг сонгоорой. *Өгөгдөл: /1-материаллаг, 2-оюун санааны, 3-нийгмийн, 4-ширүүн, 5-алгуур/*

| | |
|---|---|
| Шалтгаан | a……………………………………………………………………………… |
| Эрчим | b………………………………………………………………………… |

C. a-1,2,3; b-4,5 B. a-4,5; b-1,2,3 C. a-1,2; b-3,4,5 D. a-3,4,5; b-1,2

8. Нийгмийн харилцааг бүрдүүлэгч нь хэн вэ? \2 оноо \

A.Хувь хүн, гэр бүл B. Үндэстэн, угсаатан

C.Анги бүлэг D.Бүгд зөв

1. Соёлын биет бус өвд аль нь хамаарах вэ? \2 оноо \

A. Эртний дурсгалт газрууд, хадны зураг, бичээс

B. Эх хэл, ардын язгуур урлаг, баяр наадам

C. Орхоны хөндийн соёлын дурсгалт газар

D. Тухайн ард түмний түүх, соёлын үнэт зүйлс

2. Нутгийнхаа өвөрмөц онцлогийг илтгэсэн жуулчдад зориулсан гар урлал, бэлэг дурсгалын зүйлсийг бий болгох нь дараах ойлголтуудын аль нь вэ? \2 оноо \

A. Орон нутгийн соёлыг улс үндэстний хэмжээнд сурталчлан таниулах

B. Орон нутгийнхаа соёлыг хайрлан хамгаалах

C. Орон нутгийн соёлыг дэлхий нийтэд сурталчлан таниулах
D. Аялал жуулчлал нь соёлын харилцааны онцгой хэлбэр

3. Соёлын хожимдол гэдэг ойлголтод аль нь хамаарах вэ? \2 оноо \
   A. Хүн болон хүн, байгаль хоёрын харилцан үйлчлэлийн үр дүнд бий болсон гайхамшигт бүтээл, бүх талын ач холбогдол бүхий түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутаг
   B. Материаллаг соёл буюу байшин барилга, хөшөө дурсгал, археологийн олдворууд
   C. Тухайн нутгийн зон олны хөгжлийн үндэс болж буй хойч үедээ өвлүүлэн хөгжүүлсээр ирсэн бүхий л үнэт зүйл юм.
   D. Материаллаг зүйлсэд хэт их шунах нь зарим сөрөг үр дагаварт хүргэдэг.

4. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү. Уул уурхайн үйлдвэрлэлтээс болж олон тооны гол горхи ширгэж байгаа нь ............ илэрхийлж байна. \2 оноо \
   A. Соёлын үнэт зүйлс
   B. Соёлын хожимдол
   C. Соёлын хэм хэмжээ
   D. Соёлын өөрчлөлт

5. Оюуны соёлд хамаарах өгөгдлийг олно уу. \2 оноо \
   *Өгөгдөл: /1-шашин, 2-баяр наадам, 3-хөшөө дурсгал, 4-археологийн олдвор, 5-шинжлэх ухаан, 6-урлаг/*
   A. 1, 2, 5, 6
   B. 1, 4, 5, 6
   C. 2, 3, 5, 6
   D. 2, 3, 4, 5

6. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоно уу. \2 оноо \
   Хүний хязгааргүй хэрэгцээг хязгаарлагдмал нөөц баялгаар хангахыг ............ гэнэ.
   A. орон нутгийн эдийн засаг
   B. зах зээл
   C. эдийн засаг
   D. үйлдвэрлэл

7. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоно уу.
   Тухайн зах зээлд нийлүүлэх хүсэл эрмэлзэлтэй бөгөөд үйлдвэрлэх боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг ...............................гэнэ. \2 оноо \
   A. Эрэлт
   B. Зах зээлийн тэнцвэрт үнэ
   C. Нийлүүлэлт
   D. Үнэ

8. Бизнесийн хэлбэр, байршил, давуу тал, хүрэх үр дүн нь дараах ойлголтуудын алинд хамаарах вэ? \2 оноо \
   A. Бизнесийн зорилго
   B. Үйлдвэрлэлийн төлөвлөгөө
   C. Бизнесийн бүтэц, зохион байгуулалт
   D. Санхүүгийн тооцоо

9. Хүний оюуны ба биеийн хүчний чадавх нь дараах ойлголтуудын алинд нь хамаарах вэ? \2 оноо \
   A. Газар
   B. Хөдөлмөр
   C. Капитал
   D. Ур чадвар

10. Орлогын тооцооны дутууг гүйцээж тооцоолсныг сонгоорой. \2 оноо \

| Хураах ногоо | Авах хэмжээ | Борлуулах үнэ | Орлогын дүн |
|---|---|---|---|
| Төмс | 90кг | 500 | **b**………. |
| Лууван | 110кг | **a**………… | 22000 |
| Сонгино | 80кг | 100 | **c**………… |
| Орлогын дүн | | | 75000 |

   A. a-200, b-45000, c-8000
   C. a-300, b-50000, c-3000

B. a-250, b-3000, c-50000 D. a-50, b-40000, c-13000

11. Хүний эрхийн харилцаанд "Үүрэг хүлээгч " гэж ямар субъектийг хэлэх вэ? \2 оноо \

A. Иргэн B. Хувь хүн C. Бие хүн D. Төр

12. Хүний эрхийн талаарх ололт амжилтаа бататгаж, ямагт ахиц дэвшил гаргах талаар төрийн хүлээх үүрэг аль нь вэ? \2 оноо \

A. Хангах үүрэг
B. Хамгаалах үүрэг
C. Хүндэтгэх үүрэг
D. Ахиц дэвшил гаргах үүрэг

13. АНУ-ын тусгаар тогтнолын тунхаглал хэдэн онд батлагдсан бэ? \2 оноо \

A. 1764 он B. 1776 он C. 1784 он D. 1793 он

14. Хүний бүх эрх, эрх чөлөө адил тэгш хүчинтэй байх бөгөөд нэг эрх нь бусдаас илүү чухал, давуу гэж үзэж болохгүй гэдэг нь дараах зарчмуудын алинд хамаарах вэ? \2 оноо \

A. Хариуцлага хүлээх зарчим
B. Харилцан хамааралтай байх зарчим
C. Тэгш эрхийн зарчим
D. Салшгүй байх зарчим

15. 1215 онд Английн хаан Жон "Магна харта" хэмээх бичиг баримтад гарын үсэг зурсныг хүний эрхийн түүхэн баримт бичгүүдийн нэг гэж үздэг. Энэ нь дараах баримт бичгийн аль нь вэ? \2 оноо \

A. Зөвшилцлийн гэрээ
B. Хаммураби хааны хууль
C. Тусгаар тогтнолын тунхаглал
D. Күнзийн сургаал

16. Гарч буй бодлого, шийдвэрийн агуулга, цар хүрээ, найруулга зэргийг мэргэжлийн ажилтнууд эсвэл, хурлын төлөөлөгчид, Засаг даргын ажлын алба боловсруулдаг. Энэ нь бодлого шийдвэр гаргах үйл явцын аль үе шат вэ? \2 оноо \

A. хэрэгжүүлэх
B. хэлэлцэх
C. үнэлгээ хийх
D. боловсруулах

17. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоно уу. \2 оноо \

Тодорхой нутаг дэвсгэрт аж төрөн суугаа хүмүүс, тэдний төлөөлөл өөрсдийн амьдрал аж ахуйд хамаатай бүхий л асуудлыг орон нутгийнхаа санхүү эдийн засгийн боломждоо тулгуурлан хууль тогтоомжийн хүрээнд хамтран шийдвэрлэх эрх мэдлийг ........................... гэнэ.

A. Орон нутгийн удирдлага
B. Шийдвэр гаргах үйл явц
C. Нутгийн өөрөө удирдах ёс
D. Иргэдийн Нийтийн Хурал

18. Монгол Улсын засаг захиргааны анхан шатны нэгж нь аль вэ? \2 оноо \

A. Баг, хороо B. Сум, дүүрэг C. Аймаг D. Нийслэл

19. ИНХ, ИТХ-ын тэргүүлэгчдээс гарч буй шийдвэрийг хэрхэн нэрлэдэг вэ? \2 оноо \

A. Зарлиг B. Захирамж C. Тушаал D. Тогтоол

20. Тухайн орон нутагт хүүхдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд насанд хүрэгчдэд нөлөөлж, хамтран ажилладаг сонгуульт байгууллагыг нэрлэнэ үү. \2 оноо \

A. Хүүхдийн нэгдсэн зөвлөл
B. Сургууль
C. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
D. НҮБ

21. Орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцыг зөв дараалалд оруулсныг сонгоорой.

*Өгөгдөл: /1-Санаачлах, 2-Хэрэгжүүлэх, 3-Боловсруулах, 4-Хэлэлцэх, 5-Батлах, 6-Үнэлгээ хийх/* \2 оноо \

A. 1, 3, 5, 4, 2, 6 C. 1, 3, 4, 5, 2, 6
B. 1, 3, 5, 4, 2, 6 D. 1, 4, 3, 5, 2, 6

22. Ангийн сурагчид, багш нарын зөвлөл, спортын баг, улс төрийн нам нь аль бүлэгт хамаарах вэ? \2 оноо \
A. Бүлэг B. Албан бүлэг C. Албан бус бүлэг

31. Эдийн засгийн тогтолцооны хэлбэрт илүүц ойлголт дурьдсан бол олж дугуйлна уу?2 оноо\
A. Уламжлалт эдийн засаг B. Төвлөрсөн эдийн засаг (Захиргаадалтын)
C. Холимог эдийн засаг D. Зах зээлийн эдийн засаг

32. ................................ нь монгол улсын харьяат иргэн болохыг баталж буй анхны баримт бичиг юм.
A. Иргэний үнэмлэх B.Төрсний гэрчилгээ C.Гадаад паспорт

33............... нь гэрлэлт дээр үндэслэн бий болж нийгмийн өмнө хамтын хариуцлага хүлээдэг хүмүүсийн нэгдэл юм.
A.Гэр бүл B. Гэрлэлт C.Гэр бүлийн харилцаа

34. ............ гэдэг нь тухайн бүлгийн гишүүдийн харилцаа албан ёсны дүрэм, журам, эрх үүргээр зохион байгуулагдсан тогтвортой бүлэг
юм. A.Бүлэг B.Албан бүлэг C.Албан бус бүлэг

35. Байгууллагын бүтцэд хамаарахгүй ойлголтыг дугуйлна уу?
A. Удирдах албан тушаалтан B. Гүйцэтгэх албан тушаалтан
C. Хяналтын албан тушаалтан D.Үйлчилгээний ажилтан

**2-Р ХЭСЭГ**

36. 7-14 хүртэлх насны хүмүүс хамаарна. Өөртөө хохиролгүй хиймэгц биелэх ахуйн чанартай жижиг хэлцэл хийх эрхтэй. Тэдний нэрийн өмнөөс эцэг, эх, асран хамгаалагч нь хариуцлага хүлээдэг. Энэ нь эрх зүйн ямар чадамж вэ? \6 оноо \
.................................................................................................................................................

37. Дараах ойлголтыг зөв тохируулна уу? \6 оноо \

| | | | |
|---|---|---|---|
| 1 | ................ | A | Газар, газрын гадаргуу түүний хэдлийд орших байгалийн баялаг юм. |
| 2 | ................ | B | Хүний оюуны болон биеийн чадавхи |
| 3 | Капитал | C | Машин техник, барилга, эд хогшил, түүхий эд материал, бэлэн мөнгө |
| 4 | Ур чадвар | D | Газар, хөдөлмөр, капиталыг нэг үйлдвэрийн газарт нэгтгэн үр ашигтай удирдах чадвар. |

38 . Тохиолдол шинжилнэ үү? \6 оноо \
Нэгэн хорооны иргэд бүгдээрээ хэлэлцэн айл бүр хашаандаа гэрэлтүүлэг тавих, гудамжиндаа эргүүл гаргах ажлыг санаачлан зохион байгуулжээ. Энэ нь үйл ажиллагаанд хорооны засаг дарга, тамгын газрын ажилтнууд мэдээллээр хангаж, санхүүгийн дэмжлэг үзүүлжээ. Хамтын ажиллагааны үр дүнд “айл хүний амь нэг, саахалт айлын санаа нэг” гэдэгчлэн тухайн хороонд гэмт хэрэг гарах нь багасаж, эмэгтэйчүүд , хүүхдийн айж явдаг, гудамж гуу жалга аюулгүй болжээ.
1. Асуудлыг шийдхийн тулд хорооны иргэд ямар байгууллагад хандах ёстой вэ?
...............................................................................................................................................

39. Бүх хүмүүст нийтлэг байх нэгдсэн зорилгод хүрэхийн тулд үйл ажиллагаа нь хууль ёсны удирдлага, чиг үүрэг, хэм хэмжээгээр зохицуулагдсан албан бүлгийг ................... гэнэ. ............... бол нийгмийн тодорхой харилцаа, хэм хэмжээг зохицуулж байдаг дэд тогтолцоо, тогтвортой нэгдэл юм. \6 оноо \
…………………………………………………………………………………………………

40. .................. нь байгууллагын үнэт зүйлс болон ажилтнуудын зан үйлийн жишгийг тогтоосон үндсэн баримт бичиг юм. \6 оноо \

БАТЛАВ

ЗАХИРАЛ Б.БАТСҮХ

2024.06.03.

ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 8-Р АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛЭЭР АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

**ХУВИЛБАР “В”**

Хугацаа: 60 минут Сурагчийн нэр:

Нийт оноо: 100 Нэгдүгээр хэсэг 35 даалгавар 70 оноо

Хоёрдугаар хэсэг 5 даалгавар 30 оноо

**САНАМЖ**

- Даалгаврыг 60 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

1. .................... нь нийтлэг хэрэгцээ, сонирхол бүхий хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллагуудын хоорондын харилцаан дээр үндэслэн оршин тогтнодог.

A.Нийгэм B.Нийгмийн харилцаа C.Нийгмийн бүлэг

2. Хүмүүс өөртөө байхгүй зүйлийг бусдаас авах, солилцоо хийх замаар бусадтай харилцдаг гэж үзсэн. Үүнийг ямар нэр томьёогоор тайлбарласан бэ? \2 оноо \

A. Механик эв нэгдэл C. Хэрэгцээний онол

B. Органик нэгдэл D. Томас-Киллманы загвар

3. Нийгмийн хэн бүрдүүлдэг вэ?\2 оноо\

A.Хүмүүс B.Байгууллага C. Бүлэг

4. ............. гэдэг нь тухайн бүлгийн гишүүдийн харилцаа албан ёсны дүрэм, журам, эрх үүргээр зохион байгуулагдсан тогтвортой бүлэг юм. \2 оноо\

A.Бүлэг B.Албан бүлэг C.Албан бус бүлэг D. Зонхилогч бүлэг

5. Зөрчилдөөний ангилалаас илүүцийг нь сонгоно уу?\2 оноо\

A. Шалтгаан B. Хэлбэр C. Цар хүрээ D. Сөргөлдөх

6. Соёлын биет бус өвд аль нь хамаарах вэ? \2оноо\

A. Эртний дурсгалд газрууд, хадны зураг, бичээс
B. Ардын дуу, бүжиг, баяр наадам, аман зохиол
C. Тухайн ард түмний түүх, соёлын үнэт зүйлс
D. Баянхонгор аймгийн Цагаан агуйн дурсгалт газар

7. Орчноо цэвэр байлгах, хичээл сургуульдаа явах, амарч зугаалах зэрэг нь соёлын ямар хэлбэрийг илэрхийлж байна вэ? \2оноо\

A. Соёлын хэм хэмжээ C.Соёлын хожимдол

B. Соёлын нэвчилт D.Соёлын даяаршил

8. Худал хэлэхгүй байх, хулгай хийхгүй байх, үүрэг хариуцлагаа эрхэмлэдэг байх гэх мэт зан араншин, авир үйлдлийг зохицуулдаг. \2 оноо\

A. Зан заншил B. Ёс суртахуун C. Албан хэм хэмжээ D. Албан бус хэмжээ

9. Оюуны соёлд хамаарах өгөгдлийг олно уу. \2 оноо \

Өгөгдөл: /1-баяр наадам , 2-археологийн олдвор , 3-урлаг , 4-шашин , 5-шинжлэх ухаан, 6-хөшөө дурсгалд/

A. 1, 2, 5, 6 B. 1, 3, 4, 5 C. 2, 3, 5, 6 D. 2, 3, 4, 5

10. Соёл хэм хэмжээ гэдэг ойлголтод аль хамаарах вэ? \2 оноо\
A. Өдөр тутмын аж төрөхүйд баримталдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил, уламжлал тэргүүтнийг бүхэлд нь хүмүүсийн харилцаа, нийгмийн дэг журмыг зохицуулдаг.
B. Хүмүүсийн амьдралын хэв маяг, соёлын өөрчлөлтөд байгалийн хүчин зүйлс бас нөлөөлдөг.
C. Тухайн нутгийн зон олны хөгжлийн үндэс болж буй хойч үедээ өвлүүлэн хөгжүүлсээр ирсэн бүхий л үнэт зүйл юм.
D. Материаллаг зүйлсэд хэт их шунах нь зарим сөрөг үр дагаварт хүргэдэг.

11. ……………………. аймаг, нийслэл, сум дүүрэг, баг хорооны нутаг дэвсгэр дэх хүн ам, аж ахуй эрхлэлт , эдийн засгийн бүтэц, зах зээлийн харилцаа, орон нутгийн орлоготой холбоотой багц асуудлыг багтаана. \2 оноо\
A. Орон нутгийн эдийн засаг
C. Эдийн засаг
B. Зах зээл
D. Үйлдвэрлэл

12. Худалдан авагчийн хүсэл сонирхлын үндсэн дээр тодорхой үнээр худалдан авах боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг........................ гэнэ. \2 оноо\
A. Эрэлт
C. Нийлүүлэлт
B. Зах зээлийн тэнцвэрт үнэ
D. Үнэ

13. Иргэдээс бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахдаа төлж буй мөнгөн дүнг........ гэнэ. \2оноо\
A. Эрэлт
C. Нийлүүлэлт
B. Зах зээлийн тэнцвэрт үнэ
D. Үнэ

14. Орлогын тооцооны дутуүг гүйцээж тооцоолсныг сонгоорой. \2 оноо \

| Хураах ногоо | Авах хэмжээ | Борлуулах үнэ | Орлогын дүн |
|---|---|---|---|
| Алим | 90кг | 2000 | b………. |
| Мандарин | 110кг | a………… | 220000 |
| Анар | 80кг | 1750 | c………… |
| Орлогын дүн | | | 75000 |

a. a-2000, b-180000, c-140000
b. a-2000, b-160000, c-130000

15. Хүний эрхийн харилцаанд “Эрх эдлэгч” гэж ямар субътийг хэлэх вэ? \2оноо\
A. Иргэн
B. Хувь хүн
C. Бие хүн
D. Төр

16. Төр хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хууль тогтоомжоор баталгаажуулах талаар төрийн хүлээх үүрэг аль нь вэ?
A. Хангах үүрэг
C. Хүндэтгэх үүрэг
B. Хамгаалах үүрэг
D. Ахиц дэвшил гаргах үүрэг
C.

17. Вавилон улсын Хаммураби хааны хууль хэдэн онд батлагдсан бэ?
D. 1764 он
B. 1776 он
C. 1784 он
D. 1750 он

18. Хүний нэг эрх зөрчигдөхөд, бусад эрх мөн зөрчигдөх үндэс болно. Иймд хүний эрхийн бүхий л асуудлыг өөр хооронд нь харилцан хамааралтай цогц байдлаар шийдвэрлэх ёстой гэдэг нь дараах зарчмуудын алинд хамаарах вэ? \2 оноо \
A.Хариуцлага хүлээх зарчим
C. Тэгш эрхийн зарчим
B.Харилцан хамааралтай байх зарчим
D. Салшгүй байх зарчим

19. Тухайн бодлого, шийдвэр хаанаас гарахаас шалтгаалж, ИТХ-ын эсвэл ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар, Засаг даргын ажлын албаны хурлаар хэлэлцүүлдэг. Энэ нь бодлого шийдвэр гаргах үйл явцын аль үе шат вэ? \2 оноо\
a. хэрэгжүүлэх
C. үнэлгээ хийх
b. хэлэлцэх
D. боловсруулах

20. Нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулан хэрэгжүүлдэг байгууллага аль нь вэ? \2 оноо\
   a. Орон нутгийн удирдлага
   b. Шийдвэр гаргах үйл явц
   C. Нутгийн өөрөө удирдах ёс
   D. Иргэдийн Нийтийн Хурал

21. Монгол улсын засаг захиргааны дунд шатны нэг аль вэ? \2 оноо\
   a. Баг, хороо B. Сум, дүүрэг C. Аймаг D. Нийслэл

22. Орон нутгийн Засаг даргаас гарч буй шийдвэрийг хэрхэн нэрлэдэг вэ? \2 оноо\
   a. Зарлиг B. Захирамж C. Тушаал D. Тогтоол

23. Тухайн орон нутагт хүүхдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд насанд хүрэгчдэд нөлөөлж, хамтран ажилладаг сонгуульт байгууллагыг нэрлэнэ үү. \2 оноо \
   A. A.Хүүхдийн нэгдсэн зөвлөл
   B. Сургууль
   C. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
   D. НҮБ

24. Орон нутгийн удирдлага хэрхэн бүрддэгийг зөв дараалалд оруулсныг сонгоорой. \2 оноо\
   \1. сумын засаг дарга, 2. дүүргийн засаг дарга, 3. аймгийн засаг дарга 4. нийслэлийн засаг дарга, 5. багийн дарга, 6. хорооны засаг дарга, 7. ерөнхий сайд\
   A. 5, 6, 2, 1, 7, 4, 3
   B. 5, 6, 1, 2, 3, 4, 7
   C. 5, 6, 3, 2, 1, 4 7
   D. 5, 6, 1, 2, 4, 3, 7

25. Хэлэлцэн тохиролцож, харилцан таатай үр дүнд хүрэхийг эрмэлзэх………………. гэнэ. \2 оноо\
A. Зайлсхийх B. Сөргөлдөх C. Хамтран ажиллах D. Харилцан буулт хийх

26. Баг хорооны, Иргэдийн Нийтийн Хуралын үйл ажиллагаанаас илүүцийг сонгоорой. \2 оноо\
A. Баг, хорооны Засаг даргыг сонгох, ажлаас чөлөөлөх
B. Эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үзүүлэх
C. Засаг дарга томилох, ажлаас нь чөлөөлөх
D. баг хорооны иргэдэд шагналд тодорхойлох

27. Билгүүн хичээлээ тараад сайн найзуудтай кино үзэв. Билгүүн ямар бүлгийн гишүүн вэ? \2 оноо\
A. Албан бүлэг B. Албан бус бүлэг C. Хувийн бүлэг D. Зонхилогч бүлэг

28. Буян дээд боловсролтой, харин түүний ах Дорж дунд сургуулийн боловсролтой. Энэ тохиолдолд хүний ямар ялгааны тухай дурьдсан вэ? \2оноо\
A. Төрөлхийн ялгаа B. Төрөлхийн бус ялгаа C. Олдмол ялгаа

29. . ............ гэдэг нь culture буюу боловсруулах гэсэн утгатай латин үгнээс гаралтай үг юм. ............-ыг олон тохиолдолд “хоёр дахь байгал” хэмээн үзэж байна. Энэ утгаараа соёл бол хүний ололт амжилтын цогцолбор юм. \2 оноо\

A. Соёл B. Олон улсын соёл C. Зонхилогч соёл D. Соёлын өөрчлөлт

30. 32. ................................ нь монгол улсын харьяат иргэн болохыг баталж буй анхны баримт бичиг юм. \2 оноо\
A. Иргэний үнэмлэх B.Төрсний гэрчилгээ C.Гадаад паспорт

31. 7-14 хүртэлх насны хүмүүс хамаарна. Өөртөө хохиролгүй хиймэгц биелэх ахуйн чанартай жижиг хэлцэл хийх эрхтэй.Тэдний нэрийн өмнөөс эцэг, эх, асран хамгаалагч нь хариуцлага хүлээдэг. \2 оноо\
A.Эрх зүйн зарим чадамж
B.Эрх зүйн бүрэн чадамж
C.Эрх зүйн бүрэн бус чадамж
D. Эрх зүйн чадамж

32. Сургууль дахь дараах бүлгүүдээс аль нь албан бүлэг вэ? \2 оноо\
A. Багш нарын зөвлөл
B. Сургуулийн захиралтай уулзахаар дугаарласан хүмүүс

C. 8а ангийн хөвгүүд

33. Төрийн тамга, түүх соёлын дурсгал, хөшөө дурсгал, эртний эдлэл гэх мэт нь соёлын ямар хэлбэр вэ? \2 оноо\
A. Соёлын биет өв  B. Соёлын биет бус өв  C. Зонхилогч соёл

34. Зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээр бараа үйлчилгээний .......................... тогтоно. \2 оноо\
A.Үнэ  B.Зах зээлийн тэнцвэрт үнэ  C.Бизнес

35. Орон нутгийн эдийн засагт хамаарах асуудалд илүүц ойлголт байгаа бол олж дугуйлна уу? \2 оноо\
A.Хүн ам, эдийн засгийн бүтэц, аж ахуй эрхлэлт
B.Засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээний байгууллагуудын хэлбэр
C.Орон нутгийн зах зээлийн харилцаа
D.Орон нутгийн төсвийн орлого, зарлагын асуудал орно.
E.Илүүц ойлголт байхгүй

**Хоёрдугаар Хэсэг**

36. Дараах ойлголтыг зөв тохируулна уу? \6 оноо \

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Газар | A | Хүний оюуны болон биеийн чадавхи |
| 2 | | B | Машин техник, барилга, эд хогшил, түүхий эд материал, бэлэн мөнгө. |
| 3 | Капитал | C | Газар, хөдөлмөр, капиталыг нэг үйлдвэрийн газарт нэгтгэн үр ашигтай удирдах чадвар. |
| 4 | | D | Газар, газрын гадаргуу түүний хэдлийд орших байгалийн баялаг юм. |

37. 14-18 нас хүртэлх буюу насанд хүрээгүй хүмүүс. Банк зээлийн байгууллагад мөнгө хадгалуулах. 14 наснаас эхлээд хүүхэд үрчлэлтийн асуудлаар өөрөө санал гаргах эрхтэй. Өөрийн эд хөрөнгөө хариуцна. Хүрэлцэхгүй бол эцэг эх харгалзан дэмжигч хариуцна. . Энэ нь эрх зүйн ямар чадамж вэ? \6 оноо \
..................................................................................................................................................

Тохиолдлыг шинжилнэ үү? \2 оноо\
Нэгэн сумын төвд ганц байдаг хүүхдийн тоглоомын талбай нь харж хандах эзэнгүйгээс нурах шахсаны хажуугаар хүмүүс ихээр цуглан архи уудаг, гэмт хэрэг мэр сэр гардаг учир иргэд ийн зүгээс санал хүсэлт гарсан. Иймд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тус тоглоомын талбайн газарт худалдаа үйлчилгээний төв барих шийдвэр гарчээ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга энэхүү шийдвэрээ тайлбарлахдаа: Тус сумын төвийн хувьд алслагдмал, томоохон худалдаа үйлчилгээний төв байдаггүй, дээр нь бид ард иргэдийнхээ амар тайван амьдралыг бодож энэхүү шийдвэрийг гаргасан".

38. Асуудлыг шийдхийн тулд сумын иргэд байгууллагад хандах ёстой вэ? \6 оноо\
……………………………………………………………………………………………………………

39. Тухайн орон нутгийн ард түмний амьдралын хэв маяг, өв соёлтой газар дээр нь танилцдаг соёлын харилцааны нэг хэлбэр юм. \6 оноо\
……………………………………………………………………………………………………………

40. ……………………………нь тодорхой хэмжээний хөрөнгө оруулж, түүнийгээ арвижуулах үйл ажиллагааг хэлнэ. Бүх төрлийн бизнесийн гол зорилго ямар нэг орлого олоход оршино. …………………………...гэдэг нь орлого олох боломжийг олж харна гэсэн үг юм. \6 оноо\

| Д/Д | ЗӨВ ХАРИУЛТ | ОНОО |
|---|---|---|
| 1 | A | 2 |
| 2 | C | 2 |
| 3 | A | 2 |

| | | |
|---|---|---|
| **4** | B | 2 |
| **5** | B | 2 |
| **6** | B | 2 |
| **7** | A | 2 |
| **8** | B | 2 |
| **9** | B | 2 |
| **10** | A | 2 |
| **11** | A | 2 |
| **12** | A | 2 |
| **13** | D | 2 |
| **14** | A | 2 |
| **15** | A | 2 |
| **16** | C | 2 |
| **17** | D | 2 |
| **18** | B | 2 |
| **19** | D | 2 |
| **20** | A | 2 |
| **21** | B | 2 |
| **22** | B | 2 |
| **23** | A | 2 |
| **24** | B | 2 |
| **25** | D | 2 |
| **26** | C | 2 |
| **27** | B | 2 |
| **28** | B | 2 |
| **29** | A | 2 |
| **30** | B | 2 |
| **31** | A | 2 |
| **32** | **A** | 2 |
| **33** | A | 2 |
| **34** | B | 2 |
| **35** | E | 2 |
| | **1-Р ХЭСЭГ** | 70 |
| **36** | Эрх зүйн бүрэн чадамж | 6 |
| **37** | 2. Хөдөлмөр 4. Ур чадвар | 6 |
| **38** | Иргэдийн нийгтийн хурал | 6 |
| **39** | Аялал жуучлал | 6 |
| **40** | Бизнес санаа | 6 |
| | **2-Р ХЭСЭГ** | 30 |